

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/69/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: <a href="mailto:munkhbayarsh@audit.gov.mn">munkhbayarsh@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: <a href="mailto:battsetsegs@audit.gov.mn">battsetsegs@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Ч.Гантулга Утас: 99372297 Цахим хаяг: <a href="mailto:tseb.audit@gmail.com">tseb.audit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Төлбөрийн акт.....	20
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 118

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,120.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 3,370.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,069.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил зэрэг хөрөнгүүдийг холбогдох дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 187,465.7 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 24 хувиар өссөн байна.

4526050094

## Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>162,313,141.03</b>	<b>106,800,586.09</b>
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	98,906,532.77	24,332,666.69
312	Банкинд байгаа	99,804,967.03	25,935,983.09
3121	Төгрөг	99,804,967.03	25,935,983.09
31211	Төрийн сангийн харилцах	99,804,967.03	25,935,983.09
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>63,292,774.00</b>	<b>80,864,603.00</b>
351	Түүхий эд материал	857,500.00	72,900.00
35130	Эм боох материал	72,900.00	72,900.00
354	Хангамжийн материал	62,435,274.00	80,791,703.00
35410	Бичиг хэргийн материал	192,000.00	960,100.00
35420	Аж ахуйн материал	4,373,700.00	13,184,642.00
35430	Сэлбэг хэрэгсэл	390,000.00	390,000.00
35440	Түлш шатах тослох материал	2,360,000.00	-
35450	барилга засварын материал	5,684,000.00	2,818,000.00
35460	Хүнсний материал	887,250.00	413,800.00
35470	Бусад хангамжийн материал	48,548,324.00	63,025,161.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,520,978,946.35</b>	<b>1,484,211,937.82</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,520,978,946.35</b>	<b>1,484,211,937.82</b>
392	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>1,510,845,226.35</b>	<b>1,474,303,077.78</b>
39201	Барилга байгууламж	1,483,109,151.00	1,483,109,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(91,890,427.70)	(126,847,474.70)
39205	Машин тоног төхөөрөмж	139,942,003.46	126,808,496.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,771,011.14)	(52,754,195.60)
39207	Тавилга, эд хогшил	39,944,760.00	39,347,536.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,340,275.79)	(10,913,671.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,585,654.08	19,987,554.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,300,427.56)	(4,434,318.37)
39217	Ном	565,800.00	-
393	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>10,133,720.00</b>	<b>9,908,860.04</b>
39301	Программ хангамж	449,720.00	449,720.00
39302	Хасагдуулга	-	(224,859.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,684,000.00	9,684,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,683,292,087.38</b>	<b>1,591,012,523.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>381,835.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>381,835.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	381,835.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,683,292,087.38</b>	<b>1,590,630,688.91</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,683,292,087.38</b>	<b>1,590,630,688.91</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	82,381,109.54	82,381,109.54
512	Хуримтлагдсан үр дүн	1,071,303,180.34	970,169,821.87
51210	Өмнөх үеийн үр дүн	1,079,347,785.75	1,071,303,180.34
51220	Тайлант үеийн үр дүн	(8,044,605.41)	(101,133,358.47)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	529,607,797.50	538,079,757.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,683,292,087.38</b>	<b>1,591,012,523.91</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,031,018,477.00</b>	<b>1,150,837,407.08</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>53,684,677.00</b>	<b>38,876,807.08</b>
120	Нийтлэг татварын бус орлого	53,684,677.00	38,876,807.08
120009	Бусад орлого	157,237.00	-
120010	Борлуулалтын орлого (Цэвэр УТӨҮГ/	-	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,592,440.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,719,000.00	21,559,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,216,000.00	17,281,707.08
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>977,333,800.00</b>	<b>1,111,961,600.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	977,333,800.00	1,111,961,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	977,333,800.00	1,111,961,600.00
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>1,039,063,082.41</b>	<b>1,249,192,447.67</b>
21	Урсгал зардал	1,039,063,082.41	1,249,192,447.67
210	Бараа, үйлчилгээний зардал	1,027,238,282.41	1,236,510,247.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	769,923,653.04	957,389,393.28
210101	Үндсэн цалин	489,897,166.72	578,750,745.27
210102	Нэмэгдэл цалин	256,746,788.49	351,710,725.96
210104	Урамшуулал	23,279,697.83	26,927,922.05
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	98,458,297.88	110,388,490.75
210201	Тэтгэврийн даатгалын	66,938,300.00	75,072,067.75
210202	тэтгэмжийн даатгалын	7,875,100.00	8,832,631.50
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,937,499.12	4,418,115.75
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,976,899.40	4,418,112.75
210205	ЭМ-ийн даатгалын	15,730,499.36	17,647,563.00
2105	Нормативт зардал	63,496,345.50	74,549,685.00
210502	Хоол, хүнс	63,496,345.50	74,549,685.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	2,220,100.00	1,348,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,220,100.00	1,348,000.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	93,139,885.99	92,834,678.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,245,400.00	7,301,363.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,506,600.00	6,938,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,387,885.99	78,595,315.73
213	Урсгал шилжүүлэг	11,824,800.00	12,682,199.91
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	11,824,800.00	12,682,199.91
3	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(8,044,605.41)</b>	<b>(98,356,040.59)</b>
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	-	3,042,670.68
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>2,778,317.88</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгө	-	264,352.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гэрз	-	2,513,965.08
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(2,778,317.88)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(8,044,605.41)	(101,133,358.47)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	977,491,037.00	1,111,996,600.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	157,237.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	157,237.00	35,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	157,237.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	157,237.00	35,000.00
120009	Бусад орлого	-	35,000.00
1330	Төсвийн захирагчдаас	157,237.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	977,333,800.00	1,111,961,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	977,333,800.00	1,111,961,600.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	968,698,346.69	1,171,289,983.94
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	968,698,346.69	1,171,289,983.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	956,873,546.69	1,158,607,784.03
210101	Үндсэн цалин	769,923,653.01	957,389,393.28
210102	Нэмэгдэл	489,897,166.72	578,750,745.27
210104	Урамшуулал	256,746,788.46	351,710,725.96
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,279,697.83	26,927,922.05
210201	Тэтгэврийн даатгалын	98,438,598.18	110,388,490.75
210202	Тэтгэмжийн даатгалын	66,938,300.00	75,072,067.75
210203	ҮОМШӨ-ий даатгалын	7,875,100.00	8,832,631.50
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,937,499.12	4,418,115.75
210205	Эрүүл мэндийн даатгалын	3,937,500.00	4,418,112.75
2105	Нормативт зардал	15,750,199.06	17,647,563.00
210502	Хоол, хүнс	63,887,795.50	73,694,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	63,887,795.50	73,694,400.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,570,100.00	2,422,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,570,100.00	2,422,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,053,400.00	14,712,700.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	14,170,200.00	7,733,900.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,883,200.00	6,978,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	11,824,800.00	12,682,199.91
2220	Дотоод эх үүсвэрээр	11,824,800.00	12,682,199.91
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,478,700.00	14,575,600.00
3	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	8,478,700.00	14,575,600.00
6	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	8,792,690.31	(59,293,383.94)
8	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	(8,478,700.00)	(14,575,600.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	313,990.31	(73,868,983.94)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,490,976.75	99,804,967.03
		99,804,967.03	25,935,983.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	<i>Лөгрөгөөр/</i>			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
<b>2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>82,381,109.54</b>	<b>529,607,797.50</b>	<b>1,071,303,180.34</b>	<b>1,691,336,692.79</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(8,044,605.41)	(8,044,605.41)
<b>2025 оны 01 дугаар сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>82,381,109.54</b>	<b>529,607,797.50</b>	<b>1,071,303,180.34</b>	<b>1,683,292,087.38</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	8,471,960.00	-	8,471,960.00
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(101,133,358.47)	(101,133,358.47)
<b>2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>82,381,109.54</b>	<b>538,079,757.50</b>	<b>970,169,821.87</b>	<b>1,590,630,688.91</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					<i>/төгрөгөөр/</i>	
Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь	
1	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО</b>	<b>1,286,878,100.00</b>	<b>1,272,481,225.01</b>	<b>(14,396,874.99)</b>	<b>98.9</b>	
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,111,961,600.00</b>	<b>1,111,961,600.00</b>	-	100	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,111,961,600.00	1,111,961,600.00	-	100	
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>174,916,500.00</b>	<b>160,519,625.01</b>	<b>(14,396,874.99)</b>	<b>91.8</b>	
132001	Орон нутгийн төсвөөс	174,916,500.00	160,519,625.01	(14,396,874.99)	91.8	
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>99,647,760.03</b>	-	<b>(99,647,760.03)</b>	-	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	99,647,760.03	-	(99,647,760.03)	-	
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,386,525,860.03</b>	<b>1,272,516,225.01</b>	<b>(114,009,635.02)</b>	<b>91.8</b>	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,381,724,000.00</b>	<b>1,337,196,108.95</b>	<b>(44,527,891.05)</b>	<b>96.8</b>	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,369,041,800.00</b>	<b>1,324,513,909.04</b>	<b>(44,527,890.96)</b>	<b>96.8</b>	
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>962,155,200.00</b>	<b>957,389,393.28</b>	<b>(4,765,806.72)</b>	<b>99.5</b>	
210101	Үндсэн цалин	578,958,000.00	578,750,745.27	(207,254.73)	100	
210102	Нэмэгдэл	354,525,100.00	351,710,725.96	(2,814,374.04)	99.2	
210104	Урамшуулал	28,672,100.00	26,927,922.05	(1,744,177.95)	93.9	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>119,583,300.00</b>	<b>110,388,490.75</b>	<b>(9,194,809.25)</b>	<b>92.3</b>	
210201	Тэтгэврийн даатгал	81,097,100.00	75,072,067.75	(6,025,032.25)	92.6	
210202	Тэтгэмжийн даатгал	9,621,600.00	8,832,631.50	(788,968.50)	91.8	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,810,700.00	4,418,115.75	(392,584.25)	91.8	
210204	Ажилгүйдлийн даатгал	4,810,700.00	4,418,112.75	(392,587.25)	91.8	
210205	Эрүүл мэндийн даатгал	19,243,200.00	17,647,563.00	(1,595,637.00)	91.7	
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>140,716,500.00</b>	<b>126,319,675.01</b>	<b>(14,396,824.99)</b>	<b>89.8</b>	
210301	Гэрэл, цахилгаан	17,969,400.00	13,886,553.61	(4,082,846.39)	77.3	
210302	Түлш, халаалт	112,830,100.00	103,437,441.40	(9,392,658.60)	91.7	
210303	Цэвэр, бохир ус	9,917,000.00	8,995,680.00	(921,320.00)	90.7	
2105	<b>Нормативт зардал</b>	<b>78,984,900.00</b>	<b>73,694,400.00</b>	<b>(5,290,500.00)</b>	<b>93.3</b>	
210502	Хоол, хүнс	78,984,900.00	73,694,400.00	(5,290,500.00)	93.3	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>34,200,000.00</b>	<b>14,560,850.00</b>	<b>(19,639,150.00)</b>	<b>42.6</b>	
210604	Урсгал засвар	34,200,000.00	14,560,850.00	(19,639,150.00)	42.6	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,078,600.00</b>	<b>2,022,800.00</b>	<b>(2,055,800.00)</b>	<b>49.6</b>	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,078,600.00	2,022,800.00	(2,055,800.00)	49.6	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,323,300.00</b>	<b>40,138,300.00</b>	<b>10,815,000.00</b>	<b>137</b>	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,344,500.00	33,159,500.00	10,815,000.00	148	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,978,800.00	6,978,800.00	-	100	
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,682,200.00</b>	<b>12,682,199.91</b>	<b>(0.09)</b>	<b>100</b>	
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,682,200.00	12,682,199.91	(0.09)	100	

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,682,200.00	12,682,199.91	(0.09)	100
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>9,189,100.00</b>	<b>9,189,100.00</b>	-
	Дотоод эх үүсвэрээр	-	9,189,100.00	9,189,100.00	-
223001	Бусад хөрөнгө	-	14,575,600.00	14,575,600.00	--
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	23,764,700.00	23,764,700.00	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,381,724,000.00</b>	<b>1,346,385,208.95</b>	<b>(35,338,791.05)</b>	<b>97.4</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	99,647,730.03	99,647,730.03	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	25,935,983.09	25,935,983.09	-
3	Төсвийн байгууллага	2	1	(1.00)	50
5	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	36	36	-	100
6	Удирдах ажилтан	1	1	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	23	23	-	100
8	Үйлчлэх ажилтан	12	12	-	100

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр цэцэрлэг нь "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэн, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангаж, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, үр ашгийн дэмжих" гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах Стратегийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж цэцэрлэгийн менежментийг сайжруулах
- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөх
- Чанартай боловсрол олгох замаар байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Тасралтгүй хөгжүүлэх сургалтын тогтолцоо арга зүйг нэвтрүүлэх
- Орчин үеийн шаардлагад нийцэхүйц сургалтын орчныг бүрдүүлэх
- Багш нарын тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх
- Гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Багш ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулах

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" батлагдаж, үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтын талаар олж авсан ойлголтод үндэслэн, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн

программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам"-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэг нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр, Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар шинэчлэн баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92,279.6 мянган төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	99,647.7	25,935.9	(73,711.8)
Авлага	-	-	
Бараа материал	62,508.2	80,864.6	18,356.4
Үндсэн хөрөнгө	1,520,978.9	1,484,211.9	(36,767.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,683,134.9</b>	<b>1,591,012.5</b>	<b>(92,122.4)</b>
Өр төлбөр	-	381.8	(381.8)
Байгууллагад өгөх өглөг	-	381.8	(381.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,683,134.9	1,590,630.7	(92,504.2)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,683,134.9</b>	<b>1,591,012.5</b>	<b>(92,122.4)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 99,647.7 мянган төгрөг болж өмнөх оноос 73,711.8 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн зардлын сан, хүүхдийн хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80,864.6 мянган төгрөг болж 18,356.4 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 17,281.7 мянган төгрөгийн бараа материал, төсвийн хөрөнгөөр 121,862.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны А/21 тоот тушаалын дагуу 4,899.7 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлэн авч, үйл ажиллагаанд 115,619.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,484,211.9 мянган төгрөг болж 36,767.0 мянган төгрөгөөр буурсан нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,120.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 3,370.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,069.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч,

аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2026 оны А/01 тоот тушаалаар 8,471.9 мянган төгрөгийн анхны өртөг бүхий, элэгдлээрээ өртөгөө нөхсөн цаашид ашиглах хөрөнгийн хугацааг сунгаж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2026 оны 01-А/05 тоот захирамжаар 26,549.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 78,595.3 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,590.6 мянган төгрөг болж 92,504.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,598,375.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 138,430.9 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,736,806.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2025 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 1,173,010.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 136,430.9 мянган төгрөг буюу нийт 1,309,441.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,111,961.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 174,916.5 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 99,647.8 мянган төгрөг нийт 1,386,525.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 160,519.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 35.0 мянган төгрөг, улсын төсвөөс 1,111,961.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зарцуулж, оны эхний үлдэгдэл 99,804.9 мянган төгрөг, зарцуулаагүй үлдсэн 73,869.0 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,337,196.1 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 14,396.9 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэл т
1	Хүүхэд хамгаалал 80233	1,686.1	1,686.1	-	100.0
2	Эрүүл мэндийг дэмжих 81605	1,527.3	1,527.3	-	100
3	Цэцэрлэгийн хүүхдийн хоол 81807	78,984.9	73,694.4	(5,290.5)	93.00
4	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр 81816	2,875.2	2,875.2	-	100.00
5	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх 81823	1,348.3	1,348.3	-	100.00
6	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 81834	1,085,791.2	1,074,134.50	(11,656.7)	98.93

7	Тогтмол зардал 80111	174.916 5	160.519 63	(14.396 8)	100 00
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 81835	34.594 5	30.599 4	( 3 995 1)	88 50
	Дүн	1.381.724 0	1.337.196 1	(44.527 9)	96 80

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж

заасны дагуу Дархан Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "ЦЭСБ-Аудит" ХХК-ийн аудитор Ч.Гантулга гүйцэтгэж анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,173,010.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,730.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан Уул аймгийн Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 715.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,316.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснээс биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	2	-	2	-	100%
Албан шаардлага	1	2,316.0	1	2,316.0	100%
Төлбөрийн акт	2	715.5	2	715.5	100%
Нийт дүн	5	3,031.5	5	3,031.5	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 5,641.3 мянган төгрөгийн зөрчилд<sup>1</sup> төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 5,041.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

##### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1. Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Н.Баясгалангийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д "Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

##### 5.2 Албан шаардлага

**5.2.1. Илрүүлэлт:** Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Н.Баясгалан нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хэвсран хариуцуулна. Хэвсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн эрхлэгч Н.Баясгаланд Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын шийдвэргүйгээр ээлжийн амралтын цалин 2,897.3 мянган төгрөгийг урьдчилан тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д "Захирах, захирагдах есыг баримтлах", Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны Б/17 тушаал "Ээлжийн амралт батлах тухай", Хөдөлмөрийн гэрээний 5.2.4-д "Энэхүү гэрээний дагуу эрхлэх ажил, үүрэгтэй нь холбоотой ажил олгогчоос тогтоосон дотоод дүрэм, журам бусад тушаал, шийдвэрийг мөрдөн ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч Н.Баясгалангийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Н.Баясгалан нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,144.0	-	-	1	2,144.0	-	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн эрхлэгч Н.Баясгалагд Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын шийдвэргүйгээр ээлжийн амралтын цалин 2,897.3 мянган төгрөгийг урьдчилан тооцож, олгосон байна.	1	2,897.3	-	-	1	2,897.3	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>5,641.3</b>	<b>1</b>	<b>600.0</b>	<b>2</b>	<b>5,041.3</b>	-	-	-	-	-	-	-